



## “ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭВЛЭХ ҮЙЛДВЭР” ТӨААТҮГ-ЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:**

Үндэсний Аудитын газар  
САГ-ын захирал бөгөөд  
Тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас:261663

Аудитын менежер: Г. Гүнжидмаа  
Утас: 261628

Аудитор: Б. Уянга  
Утас: 261628

Засгийн газрын IV байр  
Бага тойруу

Улаанбаатар-46  
Монгол улс  
Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

“Атланта баланс аудит” ХХК  
Захирал Г. Жаргал  
Утас: 99105629

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн  
санхүүгийн тайлан

Хавсралт 4: Аудитын хураангуй  
тайлан

Хавсралт 5: Зөрчлийн нэгтгэл

Хавсралт 6: Асуудлын бүртгэл

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

## АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	
2	Аудитын тайлан	
2.1	Оршил	
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1-2
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим, түүний үр дүн	2-3
2.5	Дотоод хяналт	3
2.6	Орлого зардлын гүйцэтгэл, түүний талаархи мэдээлэл	3-4
2.7	Шилэн дансны мэдээлэл	4
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9	Аудитаар илрүүлсэн алдаа. зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4-5
2.10	Анхаарал татахуйц бусад асуудал	5
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	5
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	5
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	5
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.15	Санал, дүгнэлтийн хэлбэр үндэслэл	5
3	Менежментийн захидал	6
3.1	Дансны төлөвлөгөөний талаар	7
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	8
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	8-9
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	10
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	11
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	12-13
4.5	Аудит хийгдсэн төлөвлөгөө, гүйцэтгэл	14

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

## **2. АУДИТЫН ТАЙЛАН**

### **2.1 Оршил**

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ын захирал Б.Отгонбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, батлагдсан төлөвлөгөөний гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгч дансны төлөвлөгөөг шинэчлэн баталж мөрдөх талаар зөвлөмж бичсэнийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харъяа “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт болно.



Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, батлагдсан заавар журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 23-наас 2018 оны 03 дугаар сарын 12–ны өдрийн хооронд хийхээр төлөвлөн, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 14-нд эцэслэн баталгаажуулж, удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн чанарын хяналтыг “Атланта баланс аудит” ХХК-ийн ахлах аудитор А.Дэнсмаа, аудитыг ахлах аудитор Б.Баярмаа нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдөр “Атланта баланс аудит” ХХК-д ирүүлсэн байна.

### **2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ-ын зорилго нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам, агентлагуудын захиалгаар орчин үеийн машин тоног төхөөрөмжөөр, олон улсын стандартад нийцсэн хэвлэлийн үйлчилгээг цаг хугацаанд нь түргэн шуурхай хүргэхэд оршино.

2017 онд харилцагч байгууллагуудын захиалгаар өргөмжлөл, диплом, мэргэжлийн боловсролын үнэмлэх, итгэмжлэх жуух бичиг, батламж, баярын бичиг, талархал зэрэг олон нэр төрлийн хэвлэмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

### **2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, аргазүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэхэд үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, гүйлгээ ихтэй 9 дансанд түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 23-г гүйцэтгэв.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаандаа 2016 онд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг бүртгэлийн “Интерактив Би Ай” ХХК-ийн “Diamond” санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлал, журам зааврын дагуу санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

## 2.5 Дотоод хяналт


Санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжиж буй эсэхийг судалсан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна. Байгууллагын дотоод хяналтыг байгууллагын удирдлага хэрэгжүүлдэг. Тус байгууллагын удирдлага нь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхэд хяналтыг сайжруулах үүднээс үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний орцын нормыг хянаж, үйлдвэрлэлийн дамжлага хооронд хүлээлцэх дэвтэр хөтлүүлсэн байна. Тайлант хугацаанд байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталж, ажилчдын сахилга батыг сайжруулах, үйлдвэрлэлийн шат дамжлагад хяналтын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр хяналтын камер суурилуулсан байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас тодорхой чиг үүргийн дагуу хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллаж байна.

## 2.6 Орлого, зардалын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ нь 2017 онд 411.0 сая төгрөгийн борлуулалтын орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 553.5 сая төгрөгийн борлуулалт хийж, төлөвлөгөөгөөг 34.6 хувиар давуулан биелүүлсэн байна.



Тайлант хугацаанд нийт зардалд 398.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс 466.5 сая төгрөгийг зарцуулж, 81.3сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

## 2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлэх шаардлагатай цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын нийт 15 гүйлгээнээс 15 гүйлгээг ил тод, нээлттэй мэдээлсэн байна. Бусад мэдээлэл хэсэг дээр ил тод мэдээлэх шаардлагатай мэдээллүүд нь бүрэн оруулсан байна.

## 2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын батламж мэдэгдлүүдийн хүрээнд 9 дансанд нийт 23 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл


Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

1. “Хэвлэлийн бүтээгдэхүүний захиалга авах, бүртгэл хөтлөх цахим систем” болох биет бус хөрөнгийг худалдан авахад нийт 37.4 сая төгрөг төлснөөс нэмэгдсэн өртгийн албан татваргүй дүн 34.0 сая төгрөгийг үйл ажиллагааны бусад зардлаар бүртгэсэн нь Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуй нэгжийн нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Биет бус хөрөнгийг орлогод авч, зардлын дүнг залруулсан.

2. Тайлант хугацаанд үндсэн хөрөнгийн худалдан авахад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татвар 6.2 сая төгрөгийг нэмэгдсэн өртгийн албан татварын өглөгөөс хасалт хийсэн нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.5-д заасан “үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн албан татварыг хасахгүй” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Нэмэгдсэн өртгийн албан татварын өглөгөөс хасалт хийсэн дүнг буцаасан, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгөд залруулга хийв.



3. Тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны төлөвлөгөө Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар мөрдөх “Аж ахуй нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”-ын жишиг дансны төлөвлөгөөтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Менежментийн захидлаар зөвлөмж өгөх

## **2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц чухал асуудал байхгүй.

## **2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд**

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ын санхүүгийн тайлангийн аудитаар мөшгөн шалгаагүй ажил гүйлгээ байхгүй болно.

## **2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл**

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 40.2 сая төгрөгийн материаллаг алдааг санхүүгийн тайланд залруулж, материаллаг бус зөрчилд менежментийн захидлаар зөвлөмж өглөө.

## **2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ын 2016 оны санхүүгийн тайланд “Их наяд аудит” ХХК- ийн хийсэн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

## **2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:**

“Төлөвлөлтийн үе шатанд ТАБ-СТА-А-1 маягтыг ашиглан материаллаг түвшинг тогтоохдоо үйл ажиллагаа нь өөрийн орлогоор санхүүждэг аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар тул 556.0 сая суурь үзүүлэлт болгон 1 хувиар буюу 5.6 сая төгрөгөөр тооцох нь зүйтэй гэж үзсэн.

Гүйцэтгэлийн үе шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илэрсэнгүй.

## **2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ -ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайланг хавсаргав.

01

ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ

### **3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно. Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ-ын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.





### 3.1 Дансны төлөвлөгөө

### Тэргүүлэх ач холбогдол №1

#### ҮАГ-ын ажиглалт

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны төлөвлөгөөг Сангийн сайдын 2014 оны 249 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын хавсралт жишиг дансны төлөвлөгөөний дагуу шинэчлэх,

#### ҮАГ-ын зөвлөмж

Тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн дансны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж ажиллах,

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ.

#### Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

#### Төсвийн захирагчийнхариу

2018 оны 3 сарын 12-ны өдрийн 36 дугаар албан бичгээр “аудитын зөвлөмжийг баримтлан ажиллана”

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**

## 4.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ /төгрөгөөр/

2017 оны 12 сарын 31-ны өдөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	108,998,507.21	148,089,282.82
1.1.2	Дансны авлага	6,070,220.00	7,236,247.15
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	63,732,910.24	52,120,712.99
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>178,801,637.45</b>	<b>207,446,242.96</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	429,620,503.08	447,506,135.77
1.2.2	Биет бус хөрөнгө	0.00	37,400,000.00
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>429,620,503.08</b>	<b>484,906,135.77</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>608,422,140.53</b>	<b>692,352,378.73</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг		
2.1.1.2	Цалингийн өглөг		

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ


2.1.1.3	Татварын өр	2,229,477.58	10,451,755.16
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	9,211,361.93	3,599,894.93
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр		
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>11,440,839.51</b>	<b>14,051,650.09</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>11,440,839.51</b>	<b>14,051,650.09</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч: төрийн	47,942,966.07	47,942,966.07
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19,040,957.77	19,040,957.77
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	319,150,000.00	319,150,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	210,847,377.18	292,166,804.80
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>596,981,301.02</b>	<b>678,300,728.64</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>608,422,140.53</b>	<b>692,352,378.73</b>



## ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ /төгрөгөөр/2017 оны 12 сарын 31-ны өдөр


д/д	Үзүүлэлт	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>411,822,760.00</b>	<b>553,472,619.23</b>
2	Борлуулалтын өртөг	302,268,307.87	406,784,901.82
3	<b>Нийт ашиг ( алдагдал)</b>	<b>109,554,452.13</b>	<b>146,687,717.41</b>
4	Түрээсийн орлого		
5	Хүүний орлого	2,522,265.68	3,386,450.10
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	503,557.50	
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	42,121,238.61	46,768,451.17
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	42,142,243.52	12,950,796.76
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг ( алдагдал)		
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал)</b>	<b>28,316,793.18</b>	<b>90,354,919.58</b>
19	Орлогын татварын зардал	2,831,679.40	9,035,491.96
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>25,485,113.78</b>	<b>81,319,427.62</b>
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>25,485,113.78</b>	<b>81,319,427.62</b>
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>25,485,113.78</b>	<b>81,319,427.62</b>
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		



## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ /төгрөгөөр/2017 оны 12 сарын 31-ны өдөр


№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	47,942,966.07	19,040,957.77	319,150,000.00	185,362,263.40	571,496,187.24
2	НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл	47,942,966.07	19,040,957.77	319,150,000.00	185,362,263.40	571,496,187.24
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				25,485,113.78	25,485,113.78
5	Бусад дэлгэрэнгүй орлого					
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
9	2016 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	47,942,966.07	19,040,957.77	319,150,000.00	210,847,377.18	596,981,301.02
10	НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
11	Залруулсан үлдэгдэл	47,942,966.07	19,040,957.77	319,150,000.00	210,847,377.18	596,981,301.02
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				81,319,427.62	81,319,427.62
13	Бусад дэлгэрэнгүй орлого					
14	Өмчид гарсан өөрчлөлт					
15	Зарласан ногдол ашиг					
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
17	2017 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	47,942,966.07	19,040,957.77	319,150,000.00	292,166,804.80	678,300,728.64




## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

“Засгийн газрын хэвлэх үйлдвэр” ТӨААТҮГ /төгрөгөөр/2017 оны 12 сарын 31-ны өдөр

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйлажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	464,748,291.50	609,534,384.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	464,244,734.00	609,534,384.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	503,557.50	
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	435,412,511.44	508,684,558.49
	Ажиллагчдад төлсөн	133,631,106.30	159,600,120.22
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	34,954,839.18	40,760,467.98
	Бараа материал худалдан авахад төлсөн	182,454,749.22	230,503,020.12
	Ашиглалтын зардалд төлсөн		
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	5,295,086.00	
	Хүүний төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	48,861,687.22	56,920,989.22
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	30,215,043.52	17,499,960.95
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>29,335,780.06</b>	<b>104,249,825.51</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,522,265.68	3,386,450.10
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого	2,522,265.68	3,386,450.10
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,458,000.00	68,545,500.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,458,000.00	31,145,500.00



	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		37,400,000.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
<b>2.3</b>	Хөрөнгө оруулалтынүйл ажиллагааны цэвэр мөнгөнгүйлгээний дүн	1,064,265.68	-65,159,049.90
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааныцэвэр мөнгөн гүйлгээнийдүн		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	30,400,045.74	39,090,775.61
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>78,598,461.47</b>	<b>108,998,507.21</b>
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>108,998,507.21</b>	<b>148,089,282.82</b>



## ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭВЛЭХ ҮЙЛДВЭР АУДИТ ХИЙГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ

2017 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр

№	Эдийн засгийн ангилал	Тайлант оны				Зөрүү	
		Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Төлөвлөгөөнөөс	
		Дүн	Хувийн жин	Дүн	Хувийн жин	Дүн	хувь
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны борлуулалт</b>	<b>411,840,000.0</b>	<b>100.0%</b>	<b>553,472,619.23</b>	<b>118.8%</b>	<b>141,632,619.23</b>	<b>34%</b>
<b>2</b>	<b>Хүүгийн орлого</b>			<b>3,386,450.10</b>	<b>0.7%</b>	<b>3,386,450.10</b>	
	Түүхий эд материал	121,800,000.0	30.6%	164,196,622.52	35.2%	42,396,622.52	35%
	Цахилгаан	2,350,000.0	0.6%	2,927,413.05	0.6%	577,413.05	25%
	Тээвэр	13,620,000.0	3.4%	14,560,222.00	3.1%	940,222.00	7%
	Түрээсийн зардал	6,299,900.0	1.6%		0.0%	(6,299,900.00)	-100%
	Сэлбэг	3,600,000.0	0.9%	3,272,409.30	0.7%	(327,590.70)	-9%
	Үндсэн хөрөнгийн элэгдэл (ҮХЭ)	10,500,000.0	2.6%	13,259,867.31	2.8%	2,759,867.31	26%
	Шуудан холбоо	1,230,000.0	0.3%	1,097,642.15	0.2%	(132,357.85)	-11%
	Үндсэн цалин	128,900,000.0	32.3%	135,904,108.94	29.2%	7,004,108.94	5%
	НДШ, ЭМД	15,468,000.0	3.9%	18,448,530.99	4.0%	2,980,530.99	19%
	Хангамж материал	390,100.0	0.1%	1,656,586.01	0.4%	1,266,486.01	325%
	Хөдөлмөр хамгаалал	1,200,000.0	0.3%	1,568,363.64	0.3%	368,363.64	31%
	Үйлдвэрлэлийн бусад зардал	29,596,000.0	7.4%	49,893,135.92	10.7%	20,297,135.92	69%
	Урсгал зардал	4,800,000.0	1.2%		0.0%	(4,800,000.00)	-100%
<b>3</b>	<b>Үйлдвэрлэлийн өртөг</b>	<b>339,754,000.0</b>	<b>85.2%</b>	<b>406,784,901.83</b>	<b>87.3%</b>	<b>67,030,901.83</b>	<b>20%</b>
<b>4</b>	<b>Томилолт, аудитын зардал</b>	<b>3,360,000.0</b>	<b>0.8%</b>	<b>5,229,200.00</b>	<b>1.1%</b>	<b>1,869,200.00</b>	<b>56%</b>
	Цалин	29,800,000.0		33,924,120.18		4,124,120.18	
	ЭМД, НДШ	3,576,000.0		4,010,058.99		434,058.99	
	Тэтгэмж, урамшуулал	3,500,000.0		3,605,072.00		105,072.00	
	Хэвлэл, бичиг хэрэг	100,000.0		-		(100,000.00)	
<b>5</b>	<b>Удирдлагын зардал</b>	<b>36,976,000.0</b>	<b>9.3%</b>	<b>41,039,251.17</b>	<b>8.8%</b>	<b>4,063,251.17</b>	<b>11%</b>
<b>6</b>	<b>Үйл ажиллагааны бус зардал</b>	<b>18,550,000.0</b>	<b>4.7%</b>	<b>12,950,796.76</b>	<b>2.8%</b>	<b>(5,599,203.24)</b>	<b>-30%</b>

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ  
САНАЛ ДҮГНЭЛТ**